

## Авлига ба шударга ёсны үнэлэмж: зөрчил, танин мэдэхүйн хариу үйлдэл

Ц.Нямсүрэн, доктор (PhD), дэд профессор  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим  
Ө.Өсөхбаяр, магистрант

*Хураангуй:* Төрт улсуудын засаглал, нийгмийн бүтцэд хохирол учруулдаг авлига хэмээх үзэгдлийг тайлбарладаг институт, эдийн засаг, соёл, сэтгэл зүйн янз бүрийн онол, арга зүй бий. Энэхүү өгүүлэлд авлига нь хувь хүний шударга ёсны үнэлэмжид хэрхэн хямрал үүсгэж, улмаар нийгмийн амьдралд ямар зөрчил, гажуудлыг бий болгодогийг когнитив диссонанс буюу когнитив зөрчлийн онолын үүднээс шинжлэх болно. Ингэхдээ авлигын хор уршигийн талаарх сэтгэгч, философичдын үзэл санаа, анхааруулгыг авч үзэн, ёс суртахууны болон нийгмийн өргөн хүрээтэй үр дагаврыг тайлбарлаж, үнэлэмжийн зөрчлийг даван туулах танин мэдэхүйн хариу үйлдлийн хэлбэрүүдийг тодорхойлохыг зорив.

**Түлхүүр үг:** Улс төр, эрх мэдэл, нийгмийн бүлэг, үнэлэмжийн хямрал, когнитив зөрчил, ёс суртахууны релятивизм, институтийн хямрал, улс төрийн идэвхгүй байдал, системийн шударга бус байдал.

Авлига нь улс орны хөгжилд урт хугацааны, тогтолцооны шинжтэй хор хохирол учруулж, зөвхөн хууль зөрчих төдий бус, нийгмийн суурь үнэт зүйлсийг доройтуулах аюул болон хувирдаг байна. Монгол Улсын “Авлигын эсрэг хууль”-д энэхүү үзэгдлийг “...албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил” хэмээн тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолт нь эрх мэдлийг урвуулан ашиглах сонирхол бүхий этгээд болон хууль бус давуу байдал гориллогч талуудын хоорондын ашиг хонжооны харилцааг онцолдог. Ийнхүү авлигыг албан тушаалаа ашиглан хувийн болон бусдын ашиг сонирхлыг хангах зорилготой хууль бус үйлдэл гэж үзэх бөгөөд үүнд шууд оролцогчдоос гадна зуучлагч этгээдүүд ч хамаарна. Авлига нь цөөн тооны оролцогчтой юм шиг атлаа нийгмийн амьдралд шударга ёсны үнэлэмжийн гүнзгий хямралыг өдөөдөг асар их хор уршигтай. Иймд энэхүү өгүүлэлд авлигыг зөвхөн засаглал, эрх зүйн асуудал бус, харин нийгмийн шударга ёсны үнэлэмжийг сууриар нь алдагдуулдаг танин мэдэхүй болон ёс зүйн үзэгдэл хэмээн авч үзэх болно.

Шударга ёс бол улс төрийн философийн суурь ойлголт бөгөөд нийгмийн институтийн анхдагч үнэт зүйл мөн (Rawls, 1971). Гэвч авлига нь энэхүү үнэт зүйлд үргэлж сөрөг нөлөө үзүүлдэгийг үе үеийн сэтгэгчид анхааруулсаар иржээ. Платоны үзсэнээр авлига нь засаглалыг гажуудуулдаг, учир нь эрх баригчид нийтийн сайн сайхнаас илүүтэй хувийн ашиг сонирхлыг урьтал болгож улмаар нийгмийг ялзралд хүргэдэг (Plato, 2007) бол Ш.Л.Монтескье үүнийг эрх мэдлийн хуваарилалтыг алдагдуулж, шударга засаглалыг дарангуйлагч засаглалаар солих боломжийг олгодог (Montesquieu, 1989) гэж дүгнэсэн байна. Харин М.Вебер авлига нь институтийн тогтолцооноос патронаж бүлэг рүү эрх мэдлийг шилжүүлж, олон нийтийн итгэлийг сулруулж, хууль ёсны эрх мэдэлд аюул заналхийлдэг (Weber, 1978) гэж үзжээ. Орчин үеийн судалгаагаар авлига нь улс орны баялгийг элитүүдийн эдийн засгийн нөөц хэрэгсэл болгохоос гадна нийгмийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлж, ардчилсан институтэд итгэх итгэлийг бууруулж байна (Rothstein, 2011). Хэдийгээр авлига нь цөөн тооны хүмүүсийн хувийн ашиг сонирхлоор хязгаарлагддаг мэт боловч түүний учруулах хор хөнөөл нь нийгмийн бүхий л давхарга, үнэт зүйлсийн тогтолцоог хамарсан өргөн хүрээтэй байдаг. Иймээс энэхүү сөрөг үзэгдлийн эсрэг талд “нийгмийн эв нэгдэл, хууль ёсны

байдлын үндэс болдог” (Rawls, 1971) шударга ёсны тухай ойлголт үргэлж дурдагддаг билээ.

Шударга ёсны зарчим ёсоор хүн бүр бусадтай ижил түвшинд суурь эрх чөлөөг эдлэх тэгш эрхтэй бөгөөд нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал нь нэгдүгээрт, хүн бүрийн давуу талд (сайн сайханд) нийцсэн, хоёрдугаарт, бүх хүнд нээлттэй албан тушаал, ажлын байртай холбоотой байхаар зохицуулагдах ёстой (Rawls, 1971). Иймээс хэн нэгэн албан тушаал, эрх мэдлээ ашиглан хууль бус давуу байдал олж авах нь тэгш эрх чөлөө болон тэгш боломжийн зарчмыг шууд зөрчиж буй үйлдэл юм.

Уг чанараараа шударга ёс нь иргэн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх түгээмэл зарчмыг агуулдаг. Гэвч авлига нь хууль бус замаар давуу байдал олж авах хэрэгсэл болохынхоо хувьд шударга ёсны энэхүү суурь үзэл санаатай шууд эсрэгцдэг. Улс төрийн институтын түвшинд авлига газар авах нь иргэдийн шударга ёсны тухай норматив чиг баримжааг системийн шинжтэй шударга бус байдлын бодит төрхтэй зөрчилдөхөд хүргэж, улмаар үнэлэмжийн гүнзгий хямралыг өдөөдөг байна. Энэхүү үнэлэмжийн хямрал, дотоод зөрчлийг когнитив зөрчлийн онолоор задлан шинжлэх боломжтой.

Шударга ёсны тухай норматив төсөөлөл болон авлигад өртсөн нийгмийн бодит байдал хоорондоо зөрчилдөх үед хувь хүний сэтгэл зүйд когнитив зөрчил үүсдэг. Леон Фестингерийн (1957) онолоор бол хүн өөрийн итгэл үнэмшил үйлдэлтэйгээ зөрчилдөх үед үүсэх тав тухгүй мэдрэмжийг багасгахын тулд итгэл үнэмшил, үйлдлийнхээ аль нэгийг өөрчлөх, эсвэл зөвтгөх арга замыг хайдаг ажээ.

Авлигын орчинд хувь хүний дотоод үнэлэмж болон гадаад нөхцөл байдлын дунд үүсэх когнитив зөрчил нь дараах үндсэн төрлөөр илэрдэг. Үүнд:

1. Албадлагаар дагаж мөрдөх зан үйл (Forced Compliance Behavior): Энэхүү зөрчил нь дээд тушаалтны зүгээс шагнал амлах эсвэл шийтгэлээр заналхийлж шударга бус шийдвэрийг тулган шаардах үед үүсдэг. Хувь хүн өөрийн шударга ёсны зарчимдаа үнэнч байх итгэл үнэмшилтэй байвч, бодит үйлдэл нь түүнийхээ эсрэг чиглэх үед үүсэх гүнзгий зөрчил юм.
2. Хүчин чармайлтын зөвтгөл (Effort Justification): Нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа, ажил хөдөлмөртөө ихээхэн цаг хугацаа, хүч чармайлт зориулсан боловч авлигын тогтолцооноос үүдэн тэрхүү зүтгэл нь үнэгүйдэх үед үүснэ. Энэ тохиолдолд хүн гаргасан хүчин чармайлтаа үнэ цэнтэй болгож харуулахын тулд авлигад суурилсан бодит байдлыг ямар нэг байдлаар зөвтгөх танин мэдэхүйн хариу үйлдэл үзүүлдэг.
3. Шийдвэр гаргалтын үеийн зөрчил (Decision Making Dissonance): Хоёр болон түүнээс дээш сонголтын өмнө тулгарах үед бий болдог. Тухайлбал, ёс суртахууны чиг баримжаагаа хадгалж үлдэх үү, эсвэл авлигаар дамжуулан эдийн засгийн өндөр ашиг хүртэх үү гэх сонголтын хооронд үүсэх сэтгэл зүйн тухгүй байдал юм.
4. Үнэт зүйлстэй зөрчилдөх зан үйл (Behavior Conflicting with Values): Авлигын харилцаанд шууд оролцсоны дараа хувь хүний дотоод “би”-гийн үнэт зүйл болон хийсэн үйлдлийн үр дүнгийн хооронд үүсэх зөрчил. Энэ нь өөрийгөө “шударга хүн” гэж үнэлэх үнэлэмжийг нураахад хүрдэг.
5. Зөрчилтэй итгэл үнэмшил (Contradictory Beliefs): “Авлига бол нийгэмд хортой, ёс бус үйлдэл” гэх ерөнхий итгэл үнэмшил болон “Авлига өгөхгүй бол ажил

бүтэхгүй, энэ нь миний боломжийг нэмэгдүүлнэ” гэх прагматик итгэл үнэмшлүүд нэгэн зэрэг орших үед үүсэх когнитив зөрчил юм.

Авлигын түвшин өндөр улс төрийн тогтолцоонд ч иргэдийн шударга ёсны үнэлэмж хадгалагдсаар байдаг. Гэвч эрх мэдэлтнүүд хариуцлагаас мултарч, институтийн зүгээс шударга ёсыг сахиулж чадахгүй байгаа бодит нөхцөл байдал нь иргэдийн дотоод итгэл үнэмшилтэй зөрчилдөж, когнитив зөрчлийг үүсгэх гол хүчин зүйл болдог ажээ.

Иргэдийн шударга ёсны үнэлэмж болон институтийн бодит чадамж хоорондын энэхүү зөрчлийг Монгол дахь авлигын нөхцөл байдлыг харуулсан статистик үзүүлэлтүүд гэрчилнэ. Хараат бус судалгааны хүрээлэнгээс (2022) гүйцэтгэсэн олон нийтийн санаа бодлын судалгаанд оролцогчдын 93 хувь нь авлигыг улс орны хэмжээнд тулгамдаж буй “маш ноцтой”/”зарим талаараа ноцтой” асуудал хэмээн үзжээ. Түүнчлэн Монгол Улс 2024 оны байдлаар авлигын төсөөллийн индексээр (2025) дэлхийн 180 орноос 114-т жагсаж байгаа нь авлигын түвшин өндөр байгааг илтгэнэ. Авлигын индексийг тодорхойлох зорилгоор хэрэгжүүлдэг дэлхийн авлигын барометр (Transparency International, 2020) судалгаанд манай орноос оролцогчдын 69 хувь нь засгийн газрын авлигын асуудал бол бидний эн тэргүүний асуудал гэсэн хариултыг өгч, судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 22 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэгэн байдлаар авлигын харилцаанд орсон гэдгээ хүлээн зөвшөөрчээ. Эдгээр үзүүлэлт нь авлига манай нийгэмд өргөн тархсан үзэгдэл болохыг харуулна. Иргэдийн шударга ёсны норматив хүлээлт, бодит байдал дээрх авлигын түгээмэл тохиолдол хооронд байнгын зөрчилдөөн тулгарах үед хувь хүн энэхүү когнитив зөрчлийг бууруулах сэтгэл зүйн арга замыг хайж эхэлдэг. Ингэхдээ нэг хэсэг нь авлигыг “байх ёстой үзэгдэл” мэтээр хүлээн авч, түүнийг аливаа үйл ажиллагааг хурдасгагч, үр дүнтэй хэрэгсэл хэмээн зөвтгөл хийх замаар үнэлэмжийн системээ өөрчилдөг. Тэд “авлига хаа сайгүй байгаа учир авч, өгөх нь тийм ч буруу зүйл биш” гэсэн хандлагыг төлөвшүүлж, когнитив зөрчлөө намжаадаг байна. Харин нөгөө хэсэг нь энэхүү зөрчлөөс үүдэлтэй тав тухгүй байдлыг арилгахын тулд улс төрийн оролцооноос татгалзах, мэргэжлийн болон нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанаас хөндийрөх, хайхрамжгүй байдал гаргах зэргээр пессимист хариу үйлдэл үзүүлнэ.

Албадлагаар дагаж мөрдөх зан үйлээс үүдэлтэй когнитив зөрчлийг иргэд үндсэн хоёр арга замаар бууруулах хандлагатай. Эхнийх нь хувь хүн өөрийн шударга ёсны чиг баримжаанд үнэнч үлдэж, дээд тушаалтнаас ирсэн хууль бус эсвэл ёс зүйгүй шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах сонголт юм. Энэхүү үйлдэл нь когнитив зөрчлийг арилгах боловч амьдрал дээр ажлаас халагдах, албан тушаал буурах зэрэг мэргэжлийн болон эдийн засгийн эрсдэлийг дагуулдаг. Нөгөөх нь бодит нөхцөл байдалд зохицож, үйлдлээ зөвтгөх замаар зөрчлийг намжаах арга зам юм. Ингэхдээ хувь хүн “энэ бол хааяа л тохиолддог зүйл”, “миний оронд хэн ч байсан ингэх байсан”, эсвэл “гэр бүл, ажлын байраа хадгалж үлдэхийн тулд үүнийг хийхээс өөр аргагүй” гэх мэтээр өөрийн итгэл үнэмшлээ бодит байдалд нийцүүлэн өөрчилдөг. Энэ нь сэтгэл зүйн тухгүй байдлыг түр зуур арилгах боловч урт хугацаандаа шударга ёсны үнэлэмж сулрах, авлигыг хүлцэх нийгмийн сөрөг хандлагыг бэхжүүлдэг байна.

Хүчин чармайлтын зөвтгөлийн тухайд иргэд авлигын орчин дахь зөрчлөө дараах байдлаар шийдвэрлэх хандлагатай. Нэгэнт их хэмжээний цаг хугацаа, нөөц бололцоо зарцуулсан ажлаа үр дүнд хүргэхийн тулд авлигын харилцаанд орох үйлдлээ “зайлшгүй хийх ёстой алхам” хэмээн зөвтгөх, эсвэл уг ажлаасаа бүрмөсөн татгалзаж нийгэм, эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжих сонголттой тулгардаг. Түүнчлэн, шинэ мэдээлэл, нөхцөл байдалд тулгуурлан авлигыг дэмжсэн итгэл үнэмшил

төлөвшүүлэх, эсвэл эсрэгээрээ ёс суртахууны хатуу байр суурь баримтлан авлигаас татгалзах замаар когнитив зөрчлөө намжааж болно.


Эдгээрээс харахад авлигаас үүдэлтэй когнитив зөрчлийг бууруулах механизмын дийлэнх нь нийгэмд сөрөг нөлөөтэй байна. Тухайлбал, иргэд авлигагүйгээр аливаа ажил бүтэхгүй хэмээн итгэж, нийгмийн идэвхтэй оролцооноос цааргалах нь улс орны эдийн засаг, хөгжлийн бүтээмжид ноцтой хор хохирол учруулдаг. Авлигыг “зайлшгүй байх ёстой зүйл” эсвэл “иргэдийн хүч хүрэхгүй асуудал” хэмээн хүлээн зөвшөөрснөөр уг тогтолцоо улам бүр системжих бөгөөд улмаар иргэдийн дунд авлига өгөх хандлага хэвийн үзэгдэл болон төлөвшинө.

Энэхүү үзэгдлийг шударга ёсны үнэлэмжийн хямрал хэмээн тодорхойлж буй нь авлигын сөрөг нөлөө зөвхөн эдийн засаг, улс төрөөр хязгаарлагдахгүй, хувь хүний үнэт зүйлийн чиг баримжаа, итгэл үнэмшил болон бүтээмжтэй амьдрах чадамжийг системтэйгээр мохоодогтой холбоотой. Үнэлэмжийн энэхүү тодорхойгүй байдал нь шударга ёсны суурь үнэт зүйлсийг үнэгүйдүүлж, системийн шударга бус байдлыг улам бэхжүүлнэ.

Авлига өргөн тархсан хэмээн төсөөлөгддөг манай нийгэмд когнитив зөрчлийг шийдвэрлэх арга замуудаас хамааран нийгмийн бүтцийн шинэ хоёр бүлэг төлөвшиж буй нь цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай нэн сонирхолтой үзэгдэл юм. Авлигаас үүдэлтэй энэхүү хоёр бүлэгт нэг талаас авлигын харилцаанд шууд болон шууд бусаар оролцож, түүнийг өөрийн үйл ажиллагааны “хэвийн” хэрэгсэл болгон зөвтгөл хийсэн хүмүүс, нөгөө талаас авлигатай холбоотой шударга бус байдалд хүчтэй өртөж, үүний улмаас нийгмийн үнэт зүйл болон институтэд итгэх итгэлээ алдсан “пессимист” хүмүүс хамаарна.

Тэгвэл авлигын тогтолцооны салшгүй хэсэг болон төлөвшиж буй эхний бүлэг нийгмийн бусад хэсгээс юугаараа ялгаатай вэ? Тэднийг тодорхойлох хамгийн гол онцлог нь шударга ёс, тэгш боломж, ёс суртахууны норматив зарчмуудыг үйл ажиллагаандаа огт харгалздаггүй мэт үйлдэл хийдэгт оршино. Тэдний хувьд авлига нь ёс бус үйлдэл биш, харин зорилгодоо хүрэх прагматик арга хэрэгсэл болон хувирдаг.

Зураг 1. Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг иргэд тодорхойлсон байдал



Эх сурвалж: “Сант Марал” сан, Улс төрийн барометр, 2016-2024 он

Нийгмийн энэхүү зааг ялгаа болон төрөөс баримталж буй бодлогын чиг хандлагыг улс төрийн барометр судалгааны сүүлийн 9 жилийн үр дүнгийн динамик харуулж байна. Тус судалгаанд оролцогчдын олонх нь Засгийн газрын үйл ажиллагааг авлигын тогтолцоонд идэвхтэй оролцогч дээрх бүлгийг дэмжихэд илүү чиглэж байна хэмээн дүгнэжээ. Энэ нь төрийн институтууд шударга ёсны норматив зарчмыг сахиулахаас илүүтэйгээр авлигыг рационализаци хийсэн бүлэгт давуу байдал олгож буйг илтгэх бөгөөд улмаар нийгмийн нөгөө хэсэгт үүссэн когнитив зөрчил, пессимист хандлагыг улам гүнзгийрүүлж буй хэрэг юм.

Мэдээж хэрэг, эдгээр хүмүүс нийгмийн статус, харьяаллын хувьд аль нэг анги давхаргад хамаарна. Гэвч тэднийг сэтгэл зүйн хувьд дотоод мөн чанараар нь нэгтгэж буй зүйл юу вэ? Когнитив зөрчлийн онолын дагуу (Festinger, 1957) хүн өөрийн итгэл үнэмшлээс гажууд үйлдэл хийхдээ дотоод сэтгэл зүйн зөрчлөө намжаахын тулд итгэл үнэмшлээ бууруулах, эсвэл бүрмөсөн үгүйсгэх замаар тэрхүү сонголтыг хийдэг. Хэрэв ийнхүү өөрийгөө зөвтгөх танин мэдэхүйн өөрчлөлт хийхгүй бол хүний оюун санаа байнгын тогтворгүй, тухгүй төлөвт ордог байна.

Тэгэхээр хувь хүн авлигын харилцаанд орох бүрдээ өөрийн ёс суртахууны чиг баримжаа, шударга ёсны үнэт зүйлийн ач холбогдлыг зориудаар бууруулдаг. Ийнхүү үнэлэмжээ ижил замаар өөрчилсөн хүмүүс нийтлэг ашиг сонирхол, ижилслээрээ нэгдэж, нийгмийн амьдралд бие даасан өвөрмөц бүлэг болон төлөвшдөг ажээ. Энэхүү бүлэг нь өөрсдийн эрх ашгийг хамгаалах, нэгнээ өмөөрөх, шударга бусаар олж авсан давуу байдлаа бэхжүүлэх болон бүлгийнхээ цар хүрээг тэлэх чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү үзэгдэл нь авлига хувь хүний ёс зүйн асуудлаас хальж, хэрхэн системжсэн авлига болон хувирдгийг тайлбарлах гол үндэслэл болно.

Харин энэхүү үзэгдлийн нөгөө туйлд, авлигын харилцаанаас татгалзаж, өөрийн үйлдэл, үнэлэмж хоорондын зөрчлийг нийгмээс хөндийрөх замаар шийдвэрлэсэн бүлэг оршдог. Тэдний хувьд шударга ёсны үнэлэмжийн чиг баримжаа нь хувь хүнийхээ түвшинд хадгалагдан үлддэг боловч, нийгмийн бодит амьдралд шударга ёс оршин тогтнох боломжгүй хэмээн үзэх пессимист хандлага давамгайлна. Ийнхүү дотоод итгэл үнэмшил нь гадаад орчны шударга бус байдалтай эвлэрч чадахгүй байгаагаас үүдэн тэд нийгмийн идэвхгүй төлөвт шилжиж, системжсэн авлигын өмнө хүчин мөхөсдөх когнитив хямралд өртдөг ажээ.

Зураг 2. Нийгэм дэх шударга ёсны төлөв байдлын үнэлгээ




Эх сурвалж: “Сант Марал” сан, Улс төрийн барометр, 2016-2024 он

Зураг 3 дахь ерөнхий дүр зургаас манай нийгэмд шударга бус байдал давамгайлж байна хэмээн үнэлэх иргэд судалгаанд оролцогчдын дийлэнх олонхыг тогтмол бүрдүүлж буй нь тодорхой байна. Энэхүү үзүүлэлт нь нийгмийн шударга ёсонд итгэх итгэл алдарч, өмнө дурдсан “пессимист” хандлага нийгмийн сэтгэл зүйд төлөвшсөнийг батлан харуулна.

Энэхүү бүлэгт хамаарах иргэд улс төрийн хувьд идэвхгүй төлөвт шилжих эсвэл бүхий л үзэгдлийг үгүйсгэх, хэт шүүмжлэлт байр суурьтай болох хандлага ажиглагддаг. Тухайлбал, “сонгууль шударга болохгүй учир санал өгөх нь утгагүй”, “миний оролцоогоор юу ч шийдэгдэхгүй тул иргэдийн хуралд оролцох шаардлагагүй”, эсвэл

“төрийн бүхий л үйл ажиллагааны цаана авлига, ашиг сонирхлын зөрчил нуугдаж буй тул ямар ч бодлогыг дэмжихгүй” гэх мэтээр улс төрийн оролцооноос системтэйгээр татгалздаг. Энэхүү бүлгийн зүгээс нийгмийн шинэчлэл, өөрчлөлтийн аливаа оролдлогыг эсэргүүцэх, боломжгүй, бүтэмжгүй талаас нь тайлбарлахыг эрмэлзэх нь үнэлэмжийн хямралыг улам гүнзгийрүүлж, нийгмийн хөгжлийг гацаах эрсдэлийг дагуулна.


Зураг 3. Хуулийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийн динамик



Эх сурвалж: “Сант Марал” сан, Улс төрийн барометр, 2016-2024 он

Дээрх динамик үзүүлэлтээс харахад шударга ёсыг сахиулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий шүүх засаглал, хууль сахиулах байгууллагад итгэх иргэдийн итгэл тогтмол сул байгаа нь ажиглагдана. Институтийн түвшний энэхүү үл итгэлцэл нь авлигын тогтолцооноос үүдэлтэй когнитив зөрчлийг гүнзгийрүүлээд зогсохгүй, нийгмийн шударга ёсны үнэлэмж унасныг давхар харуулж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл, хуулийн засаглалд итгэх итгэл алдрах тусам иргэдийн дунд “пессимист” хандлага бэхжиж, авлигыг гарцаагүй үзэгдэл хэмээн хүлээн зөвшөөрөх сэтгэл зүйн хөрс бүрдэж байна.

Зураг 4. Нийгэм-улс төрийн институтуудад өгөх иргэдийн үнэлгээ



Эх сурвалж: Хараат бус судалгааны хүрээлэн, Олон нийтийн санаа бодлын судалгаа, 2022

Судалгааны үр дүнгээс харахад нийгмийн суурь институтуудыг иргэдийн олонх нь дийлэнх тохиолдолд сөргөөр үнэлж буй нь манай нийгэмд шударга ёсны үнэлэмж хэрхэн унасныг илтгэнэ. Тухайлбал, шударга ёсыг сахиулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий шүүх засаглалд нийт оролцогчдын 66 хувь нь сөрөг үнэлгээ өгсөн бол авлигыг хязгаарлах үүрэгтэй Авлигатай тэмцэх газарт 64 хувь нь итгэл хүлээлгэсэнгүй. Авлига нь зөвхөн төрийн засаглалыг сулруулаад зогсохгүй, нийгмийн шударга ёс болон ардчилсан соёлын суурь үнэт зүйлсийг системтэйгээр мохоодог байна.

Эцэст нь дүгнэж үзвэл, авлига нь шударга бус байдлын хамгийн хор нөлөөтэй илэрхийлэмж бөгөөд философи, улс төрийн сэтгэлгээний түүхэн дэх суурь асуудлуудын нэг байсаар иржээ. Үе үеийн судлаачид авлига нь цөөн тооны этгээдэд үндэслэлгүй давуу тал олгоод зогсохгүй, нийгмийг бүхэлд нь доройтуулах хор уршигтайг онцолсоор байна. Ялангуяа авлига нийгэмд түгээмэл үзэгдэл болох үед шударга ёсны талаарх норматив үнэлэмжийг когнитив зөрчилд оруулж, улмаар хувь хүн, нийгмийн бүлгүүд шударга ёсонд итгэх итгэлээ алдах хандлага илэрдэг ажээ. Авлига хэвийн үзэгдэл мэт болох нь нийгмийн холбоог сулруулж, ёс суртахууны тодорхойгүй байдал, иргэдийн улс төрийн идэвхгүй төлөв рүү түлхэх аюултай. Хэрэв нийгмийн харилцаанд шударга ёсыг эргэн тогтоох бодит өөрчлөлт хийгдэхгүй бол энэхүү зөрчил улам эрчимжиж, нэг талаас авлига нь “бичигдээгүй хэм хэмжээ” болон институтчилэгдэх, нөгөө талаас нийгэм бүхэлдээ үл ойлголцол, туйлшрал, зөрчилдөөн рүү гүнзгий орох эрсдэлтэй байна. Энэхүү нөхцөлийг даван туулахын тулд зөвхөн институтийн шинэчлэл хангалтгүй бөгөөд үнэлэмжийн суурь өөрчлөлт зайлшгүй шаардлагатай. Шударга ёсыг нийгмийн суурь үнэт зүйл болгон дахин бататгах нь соёл, боловсрол, улс төрийн бүх түвшинд хувь хүний болон хамтын итгэл үнэмшлийг ёс суртахуунлаг үйлдэлтэй нийцүүлэн шинэчлэх асуудал юм. Үнэлэмжийн онолын үүднээс авлигыг шинжлэх нь нийгэм яагаад шударга бус байдлыг хүлцэн тэвчиж байдгийг тайлбарлаад зогсохгүй, авлигатай тэмцэх шинэчлэлийг соёл, сэтгэл зүйн саад тотгоргүйгээр хэрэгжүүлэх арга зүйн үндэслэлийг цаашид гүнзгийрүүлэн судлах хэрэгцээг дэвшүүлж байна.

### Ном зүй

- Corruption Perceptions Index*. (2025, February). Retrieved from Transparency International Mongolia: <https://www.transparency.org/en/countries/mongolia>
- Festinger, L. (1957). *A Theory of Cognitive Dissonance*. Stanford: Stanford University Press.
- Haidt, J. (2012). *The Righteous Mind: Why Good People are Divided by Politics and Religion*. New York: Pantheon Books.
- IRIM. (2022). *Олон нийтийн санаа бодлын судалгаа*. Улаанбаатар.
- Lambsdorff, J. G. (2007). *The Institutional Economics of Corruption and Reform: Theory, Evidence, and Policy*. Cambridge: Cambridge University Press.
- Montesquieu, C. de. (1989). *The Spirit of the Laws*. Cambridge: Cambridge University Press.
- Plato. (2007). *The Republic*. London: Penguin Classics.
- Rawls, J. (1971). *A Theory of Justice*. Harvard: Harvard University Press.
- Rothstein, B. (2011). *The Quality of Government: Corruption, Social Trust, and Inequality in International Perspective*. Chicago: University of Chicago Press.
- Transparency International. (2020). *Global Corruption Barometer: Asia*. Transparency International.
- Weber, M. (1978). *Economy and Society: An Outline of Interpretive Sociology*. (E. (G. Roth & C. Wittich, Trans.) California: University of California Press.

### **Corruption and the Value of Justice: Dissonance and Cognitive Responses**

*Throughout history, corruption has inflicted profound and enduring harm on nations, necessitating diverse theoretical and methodological approaches to decode its complexity. This article examines corruption not merely as a legal breach but as a fundamental catalyst for a crisis in the core value of justice. Utilizing cognitive dissonance theory, the study explores how systemic corruption bifurcates society into distinct groups: those who rationalize corrupt practices and those who fall into a state of “social pessimism.” Furthermore, by integrating the perspectives of prominent philosophers, this research elucidates the ethical erosion and societal contradictions triggered when corruption becomes normalized. The analysis underscores that overcoming this crisis requires a dual transformation of both institutional structures and fundamental social values.*